

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
219 ДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.7, 46.8 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дугаар заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоол, Монголын цахилгаан холбоо ХК-ийн “Ногдол ашгийн журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны цэвэр ашгийн 80 хувь буюу 12,218,940.09 (арван хоёр сая хоёр зуун арван найман мянга есөн зуун дөч зууны ес) төгрөгийг ногдол ашигт хуваарилж, нэгж хувьцаанд 0.47 (тэг зууны дөчин долоо) төгрөг байхаар тогтоон мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.

3. Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулан, 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгосугай.

4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, ногдол ашиг хуваарилалтын тайланг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ